



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойрлуу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2015.03.02 № 6/20

“ДЭД БҮТЭЦ- ЭРЧИМ ХҮЧ” ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ЗАХИРАЛ
П.ГАНБАТ ТАНАА

Г Албан шаардлага өгөх тухай

“Дэд бүтэц-Эрчим хүч” төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь тээвэр шатахууны зардалд 35,720,000 төгрөгөөр батлагдаж 32,711,790 төгрөг зарцуулсны шатахуун 18,320,000 төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 13,505,490 төгрөг, даатгалд 886,300 төгрөг тус тус зарцуулсан байна. Албан ажлын 3 суудлын автомашины шатахууны зарцуулалтыг “албан ажлын хэрэгцээний автомшин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын авто машиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км” байхаар тооцвол 10,500,000 төгрөг зарцуулахаар тооцоо гарч 7,820,000 төгрөгөөр хэтрүүлсэн,
2. Шатахууны картын үлдэгдэл 81580 төгрөг байгаа боловч бараа материалын тайланд бүртгээгүй, дугуй, акумлятор 1,577,733 төгрөгийн сэлбэгийг шууд зардлаар бүртгэсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь:

1. Засгийн газрын суудлын автомшины талаар авах зарим арга хэмжээний тухай 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 349 тоот тогтоолын 2-т зааснаар “албан ажлын хэрэгцээний автомшин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын авто машиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 70 км-ээс тус тус хэтэрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай” гэснийг зөрчсөн,
2. Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

“Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

Засгийн газрын суудлын автомшины талаар авах зарим арга хэмжээний тухай 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 349 тоот тогтоолыг мөрдөн ажиллаж шатахууны зардлыг норм нормативаар тооцох, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны

заавар"-ыг мөрдөн ажиллаж шатахуун, сэлбэг хэрэгслийг бараа материалын дансанд тусган нягтлан бодох бүртгэлийг хөтлөх.

Биелэлтийг 2015 оны 06 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Дэд бүтэц-Эрчим хүч” төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал П.Ганбат, Ерөнхий нягтлан бодогч С.Өнөржаргал нарт даалгав.

АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

